**МОНГОЛ УЛС**
**ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 31 өдөр Дугаар А/439 Зуунмод

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2019-2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар батлсугай.

2.Төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, Засаг даргын зөвлөлийн хуралд жил бүр тайлагнахыг Эрүүл мэндийн газар /С.Мөнхтуяа/-т үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Д.Мөнхцэцэг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ж.БАТЖАРГАЛ

010 01334

Аймгийн Засаг даргын 2019 оны
07 дугаар сарын 31-ны А/439 дугаар
захирамжийн хавсралт

**“ХАЛДВАРТ БУС ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ”**
**ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2019-2021/**

| Зорилго | “Зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчлөл, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг иргэн, гэр бүл, байгууллага, хамт олон, нийгмийн олон талт хамтын ажиллагаанд тулгуурлан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, өвчний эрт үеийн хяналт, тандалтыг сайжруулах” | | | | |
|---|---|---|---|---|---|
| Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт) | | Шалгуур үзүүлэлт | Суурь үзүүлэлт | 2019 он | 2021 он |
| | 1. | Хорт хавдраас шалтгаалсан нас баралт (10000 хүн амд ) | 12.71 | 12.0 | 10.5 |
| | 2. | Зүрх судасны тогтолцооны шалтгаант нас баралт (10000 хүн амд ) | 21.14 | 20.8 | 20.4 |
| | 3. | Бөөрний сувганцрын үрэвсэлт өвчний улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгч, хувиар | 10.50 | 10.5 | 10.0 |

| **№** | **Үйл ажиллагааны чиглэл** | **Хийх ажил** | **Шалгуур үзүүлэлт** | **Хүрэх түвшин** | | | **Хариуцах эзэн** | **Хамтран хэрэгжүүлэгч** |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | **2019** | **2020** | **2021** | | |
| **Зорилт 1. Хүн амын эрүүл аж төрөх мэдлэг, хандлагыг сайжруулах, байгууллага, аж ахуйн нэгжид эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх замаар ХБӨ-д нөлөөлж байгаа анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах** | | | | | | | | |
| 1.1 | Халдварт бус өвчлөл, тэдгээрийн эрсдэлийг бууруулахад олон нийт, бусад салбар байгууллагуудын идэвх, санаачлагыг өрнүүлэх | Орон нутгийн түвшинд Өсвөр үе, залуучуудын дунд “Архи, тамхи бидний сонголт биш” хөдөлгөөн өрнүүлж, олон нийтэд сурталчилна. | Сургалт сурталчилгааны тооны өсөлт, Хамрагдсан байгууллага, хүний тоогоор | 3<br>300 | 4<br>350 | 5<br>400 | ЭМГ, АНЭ, сум, өрхийн ЭМТ | ЕБС, МСҮТ |
| | | **Урлаг, соёл, биеийн тамир, спорт бусад олон нийтийн арга хэмжээг архи, тамхигүй зохион байгуулах талаар ухуулга нөлөөлөл, сургалт зохион байгуулна.** | **Нөлөөллийн ажил зохион байгуулсан тоогоор, Хамрагдсан байгууллага, хүний тооны өсөлтөөр** | 2<br>300 | 3<br>350 | 4<br>400 | ЭМГ, АНЭ, сум, өрхийн ЭМТ | **ТББ-ууд, Хэвлэл мэдээллийн байгууллага** |
| | | **”Эрүүл аж төрөх ухаан” салбар дундын үндэсний зөвлөгөөн зохион байгуулна.** | **Зөвлөгөөн зохион байгуулсан байдлаар** | 1 | | 1 | ЭМГ | **Аймаг, сумын ЗДТГ, ОУБ, ТББ, Хэвлэл мэдээллийн байгууллага** |
| | | **“Давсгүй цай,” "Сахаргүй цай” аян зохион байгуулж, дүгнэнэ.** | Зохион байгуулсан аян, хамрагдсан хүний тоогоор | **1**<br>**500** | 2<br>1000 | 2<br>1000 | ЭМГ, АНЭ, сум, өрхийн ЭМТ | **Аймаг, сумын ЗДТГ** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Аймгийн хэмжээнд Халдварт бус өвчинд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг үнэлэх судалгаа хийж, эрсдэлийг бууруулах ажил зохион байгуулна.** | **Судалгаа зохион байгуулсан байдал** | **1** | - | - | ЭМГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ, аймаг, сумын ЗДТГ, ОУБ, ТББ |
| 1.2 | **Архи, тамхи, бусад донтох эмгэгээс гарах, хордлого тайлах, эмчлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах** | **Архи, тамхи, мансууруулах бодисын хор хөнөөл, амиа хорлолтоос сэргийлэх сургалт хийж, гарын авлага боловсруулж тараана.** | Сургалтад хамрагдсан хүний тоо, боловсруулж тараасан гарын авлагын тоогоор | **500** | 500 | **500** | ЭМГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ |
| | | **Архины хамаарлаас гарах эмчилгээ хийлгэсэн, гарахыг хүссэн хүн, тэдний гэр бүлийн хүмүүст туслах сайн дурын клуб байгуулах, ТББ-тай хамтран ажиллана.** | **Клуб байгуулагдсан байдлаар,<br>Хамтран ажилласан ТББ-ын тоогоор** | **1**<br>**1** | **1**<br>**2** | **1**<br>**3** | ЭМГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ, аймаг, сумын ЗДТГ, ОУБ, ТББ |
| | | Архинаас гарсан залуусын хөдөлгөөнийг сурталчилна. | Архинаас гарсан хүний тооны өсөлт,<br>Сургалт, сурталчилгаа хийсэн тоогоор | 3<br>4 | 5<br>6 | 6<br>10 | ЭМГ, АНЭ, сум, өрхийн ЭМТ | ГХУСАЗЗ |
| 1.3 | Давсны хэрэглээний талаар тандалт судалгаа хийж, сургалт, сурталчилгаа, ухуулга, нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх | **Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтэнд хүн амд давсны зохистой хэрэглээний зөвлөгөө өгөх чадавх сайжруулах сургалт явуулна.** | **Чадавхжсан мэргэжилтний тоогоор** | - | 25 | 30 | ЭМГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ |
| | | **Цусны даралт ихсэлт, хавдар, ЗСӨ-ий улмаас эмчид хандаж буй хүнд натрийн агууламжийг тодорхойлж, зөвлөгөө өгнө. /Танита аппарат/** | **Зөвлөгөө өгсөн хүний тоогоор** | 500 | 600 | 700 | ЭМГ, АНЭ | АНЭ, сум, өрхийн ЭМТ |
| | | **Давсны талаар нийтэд чиглэсэн ухуулга нөлөөллийн арга хэмжээг жил бүр явуулна.** | **Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор** | 1 | 2 | 3 | ЭМГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ |
| 1.4 | **Хүн амын хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх, биеийн** | **Хүн амын хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх МСС зохион байгуулна.** | **Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор** | **15** | **15** | **15** | ЭМГ, БТСГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ, ЕБС |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **жингээ хэвийн хэмжээнд барих, илүүдэл жин, таргалалт, бие, физиологийн зохицолдоог хянах мэдээлэл, сурталчилгаар эрчимжүүлэх, үр дүнтэй ажиллаж байгаа иргэн, хамт олон, байгууллагын үйл ажиллагааг дэмжих орчин бүрдүүлэх** | **Хүний илүүдэл өөх, уураг, нүүрс ус, бие, физиологийн зохицолдоо, таргалалтыг хянах тоног төхөөрөмжөөр АНЭ, сум, өрхийн ЭМТ-ийг хангах, иргэдэд мэдээлэл, зөвлөмж өгнө.** | **Тоног төхөрөмжөөр хангагдсан ЭМТ-ийн тоогоор** | - | 2 | 3 | ЭМГ, аймаг, сумын ЗДТГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ |
| | | **Хүн амын хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэхээр үр дүнтэй ажиллаж байгаа иргэн, хамт олон, байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, урамшуулна.** | Үр дүнтэй ажиллаж байгаа иргэн, хамт олон, байгууллагын тооны өсөлтөөр, Урамшуулсан байгууллагын тоогоор | 35<br><br>3 | 38<br><br>6 | 38<br><br>9 | ЭМГ, БТСГ, аймаг, сумын ЗДТГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ |
| 1.5 | **Боловсролын байгууллагыг түшиглэн сургуулийн хүүхдийн дундах архаг халдварын голомтыг эрт илрүүлэх, эмчлэх, ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлийг бууруулах арга хэмжээ авах** | **Сургуулийн сурагчдын архаг халдварын голомт/ шүдний өвчлөл, стрептококкийн халдвар/ илрүүлэх, эмчлэх, мэдээлэх, өөрсдийн хяналтад авна.** | Эмчлэн эрүүлжүүлсэн сурагчдын тоогоор | 450 | 350 | 350 | ЭМГ, БСГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ, ЕБС |
| | | **Хүүхдийн сул хараа, харааны гажгийг 3, 6 настайд тогтмол шалгаж бүртгэх, мэдээлэх, харааг засах, хяналтад авах, шаардагдах тоног төхөөрөмжөөр хангахад цэцэрлэг, сургуультай хамтран ажиллана.** | Үзлэгт хамруулсан хүүхдийн хувиар | 3, 6 настай нийт хүүхдийн 30 хувь | 3, 6 настай нийт хүүхдийн 50 хувь | 3, 6 настай нийт хүүхдийн 60 хувь | ЭМГ, БСГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ, ЕБС, цэцэрлэг, ТББ, ОУБ |
| | | **Сурагчдын илүүдэл жин, таргалалтыг бүртгэх хянах, тандах, мэдээлэх заавар боловсруулах, сургуульд нэвтрүүлэх, сургалт зохион байгуулна.** | Сургалтад хамрагдсан хүүхдийн хувиар | **ЕБС-ийн сурагчдын 30%** | **ЕБС-ийн сурагчдын 40%** | **ЕБС-ийн сурагчдын 50%** | ЭМГ, БСГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ, ЕБС, ТББ, ОУБ |
| | | **ЕБС-ын хүүхдийн бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох скрининг үнэлгээг жил бүр хийж илүүдэл жингийн эрсдлийг эрт илрүүлэх тандалт хийнэ.** | **Бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох скрининг үнэлгээнд хамрагдсан** | **ЕБС-ийн сурагчдын 30%** | **ЕБС-ийн сурагчдын 40%** | **ЕБС-ийн сурагчдын 50%** | ЭМГ, БСГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ, ЕБС, ТББ, ОУБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сурагчдын хувиар | | | | | |
| | | **Хүүхэд, өсвөр үеийн сэтгэцийн тулгамдсан асуудлын шалтгаан, зан төлөв, өөрчлөлтийг эрт илрүүлэх, оношлох, зөвлөгөө өгнө.** | Эрт илрүүлэг, зөвлөгөө авсан сурагчдын хувиар | **ЕБС-ийн сурагчдын 5%** | **ЕБС-ийн сурагчдын 6%** | **ЕБС-ийн сурагчдын 7%** | ЭМГ, БСГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ, ЕБС, ТББ, ОУБ |
| | | **Бөөрний үрэвсэлт өвчний тархалтыг бууруулах зорилгоор сургуулийн хүүхдийн ариун цэврийн байгууламжийн хүртээмж /стандарт/- ийг сайжруулахад нөлөөллийн ажил зохион байгуулна.** | **Сургуулийн хүүхдийн ариун цэврийн байгууламж сайжирсан байдлаар,** | - | 1 | 1 | ЭМГ, БСГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ, ЕБС, ТББ, ОУБ |
| 1.6 | **Зонхилон тохиолдох ХБӨ-ий эрт илрүүлгийн товлосон үзлэг, шинжилгээнд иргэд, зорилтот бүлгийн хамралтыг сайжруулах** | **Иргэд цусны даралт, цусан дахь өөх тос, глюкоз, биеийн жинг өөрөө хянах аргад сургах аргачлалыг цахимаар сурталчилна.** | **Сурталчилгааны ажлын тоогоор** | **4** | **4** | **4** | ЭМГ, АНЭ, сум, өрхийн ЭМТ | **Хэвлэл мэдээллийн байгууллага** |
| | | **Хөх, умайн хүзүү, цусны даралт ихсэлт, чихрийн шижингийн** эрт илрүүлгийн **хамрагдалт хангалтгүй байгаа шалтгаан тогтоох судалгаа хийж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.** | Судалгаа хийсэн байдлаар, Хамрагдалтын хувийн өсөлтөөр | **1 Эрт илрүүлгийн дундаж 69%** | **1 Эрт илрүүлгийн дундаж 71%** | **1 Эрт илрүүлгийн дундаж 73%** | ЭМГ, АНЭ, сум, өрхийн ЭМТ | ОУБ, ТББ |
| 1.7 | **Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал уур бухимдал, сэтгэл гутралаас** сэргийлэх тусламж **үйлчилгээний хүртээмжийг сайжруулах** | **Уур бухимдал, сэтгэл гутралын үед өөрийгөө тодорхойлох, хянах асуумжийн аргыг нийгмийн сүлжээгээр сурталчилна.** | **Сурталчилгааны ажлын тоогоор** | **2** | 2 | 2 | ЭМГ, АНЭ, сум, өрхийн ЭМТ | **Хэвлэл мэдээллийн байгууллага** |
| | | **Сэтгэлзүйн зөвлөгөө үйлчилгээг сургууль хамт олны түвшинд сэтгэл зүйч, нийгмийн ажилтны баг бүрдүүлж ажиллуулна.** | **Нийгмийн ажилтны баг** ажилласан байдлаар | 1 | 2 | 3 | ЭМГ, БСГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ, ЕБС, ТББ, ОУБ |
| 1.8 | **Ажлын байрны болон мэргэжлийн таагүй нөлөөллөөс үүдэлтэй ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлийг бууруулах,** | **Ажиллагсдыг урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулах хөдөлгөөн өрнүүлнэ.** | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байгууллага, ААН-ний хувиар | Төрийн болон ТББ, аж ахуйн нэгжийн 40% | Төрийн болон ТББ, аж ахуйн нэгжийн 50% | Төрийн болон ТББ, аж ахуйн нэгжийн 60% | **ЭМГ, ЗДТГ** | АНЭ, сум, өрхийн ЭМТ, аймаг, сумын ЗДТГ, ОУБ, ТББ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **хамт олон, байгууллагын оролцоог идэвхжүүлэх** | **Зохистой хооллолт, хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх уралдаан өдөрлөг үзэсгэлэн, үзүүлэх сургалт зохион байгуулна.** | **Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор** | 1 | 2 | 2 | **ЭМГ, ЗДТГ** | АНЭ, сум, өрхийн ЭМТ, аймаг, сумын ЗДТГ, ОУБ, ТББ |
| | | **Эрүүл мэндийг дэмжигч цэцэрлэг, сургууль, ажлын байр, аймаг, сум болох хөдөлгөөнийг үе шаттай өргөжүүлж, урамшуулна.** | **Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тооны өсөлтөөр** | 22 | 25 | 28 | **ЭМГ, ЗДТГ** | АНЭ, сум, өрхийн ЭМТ, аймаг, сумын ЗДТГ, ОУБ, ТББ |
| Зорилт 2. ХБӨ-өөс урьдчилан сэргийлэх ажил болон эрт илрүүлэх, оношилгоо, эмчилгээний цогц тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагын оролцоонд түшиглэн бэхжүүлж, ХБӨ-тэй иргэнийг эмчийн хяналтад эрт авч, өвчлөл, нас баралтын тоог бууруулах нөхцөл бүрдүүлэх | | | | | | | | |
| 2.1 | **Эрүүл мэндийн анхан шатны тусламжид ДЭМБ- ын ХБӨ-ий урьдчилан сэргийлэлт, хяналтын нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц (PEM)-ыг нэвтрүүлж, хүн амд зөвлөгөө өгөх арга хэмжээг өргөжүүлэх** | **ХБӨ-ий урьдчилан сэргийлэлт, хяналтын нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцын эмнэлгийн хэрэгслийн хангамжийн байдалд үнэлгээ хийж, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.** | **Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцын хангалтын хувиын өсөлтөөр** | **75%** | 80% | 85% | **ЭМГ, АНЭ, сум, өрхийн ЭМТ** | Аймаг, сумын ЗДТГ, төрийн болон ТББ |
| | | **Автомат даралт хэмжигч аппарат, иргэдэд зориулсан зөвлөмжийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд төдийгүй төрийн байгууллагын ажлын байранд байлгах шаардлага тавина.** | **Суурин даралтны аппараттай болсон байгууллага, аж ахуйн нэгжийн хувиар** | Төрийн болон ТББ, аж ахуйн нэгжийн 40% | Төрийн болон ТББ, аж ахуйн нэгжийн 50% | Төрийн болон ТББ, аж ахуйн нэгжийн 60% | **ЭМГ** | Аймаг, сумын ЗДТГ, төрийн болон ТББ |
| 2.2 | **Зонхилон тохиолдох ХБӨ-ий эрт илрүүлгийн хүний нөөц, шаардагдах эм, урвалж, багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн** | Нийт хүн ам, жирэмсэн эмэгтэйчүүдийн артерийн гипертензи, чихрийн шижин хэв шинж-2, умайн хүзүү, хөх, элэг, ходоодны хавдрын эрт илрүүлгийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийнэ. | **ХШҮ хийсэн байдал, үр дүнгээр** | **2** | 22 | 2 | **ЭМГ** | АНЭ, сум, өрхийн ЭМТ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **хангамжийг үе шаттайгаар нэмэгдүүлэх** | Хөх, умайн хүзүүний хавдар, ЧШ, ЦДИ-ийн эрт илрүүлгийн үзлэгт шаардлагатай эм, урвалж, багаж хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлнэ. | Шаардлагатай эм, урвалж, багаж хэрэгслийн хангамжийн хувиар | **75%** | 80% | 85% | **ЭМГ, ЭМЯ** | АНЭ, сум, өрхийн ЭМТ |
| 2.3 | Зонхилон тохиолдох элэгний, ходоодны хорт хавдрыг эрт илрүүлэх, эмчлэх, сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх | Элэг, ходоодны хорт хавдрын эрт илрүүлэг, эмчилгээнд шаардагдах багаж хэрэгслийн хангамжийг сайжруулна. | Шаардлагатай багаж хэрэгслийн хангамжийн хувийн өсөлтөөр | **75%** | 80% | 85% | ЭМГ | Аймаг, сумын ЗДТГ |
| 2.5 | **Хөнгөвчлөх тусламж, үилчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах** | **Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг гэрээр үзүүлдэг багийг сум, багт байгуулж ажиллуулна.** | **Байгуулагдсан нэгжийн тоо, үзүүлсэн үйлчилгээгээр** | - | 3 | 5 | ЭМГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ |
| | | **Хорт хавдрын хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд шаардлагатай хямд үнэтэй, хурдан үйлчилгээтэй, уухаар хэрэглэдэг морфины хангамж, тасралтгүй байдлыг хангана.** | Эмийн хангалтын хувиар | 25% | 30% | 35% | ЭМГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ |
| | | **Хөнгөвчлөх эмчилгээний талаар гэр бүл, олон нийтийн мэдлэг, хандлага, дадлыг дээшлүүлэх гарын авлага, зөвлөмж гаргаж сургалт, сурталчилгаа хийнэ.** | **Хийсэн сургалт, сурталчилгаа, хамрагдсан хүний тоогоор** | 300 | 300 | 400 | **ЭМГ, АНЭ, сум, өрхийн ЭМТ** | Аймаг, сумын ЗДТГ, төрийн болон ТББ |
| Зорилт 3. ХБӨ, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлж, ХБӨ-ий бүртгэл, мэдээлэл, тандалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим, нээлттэй тогтолцоог орон нутаг, бусад салбар, үндэсний хэмжээнд бий болгож бэхжүүлэх | | | | | | | | |
| 3.1 | **Хүн амд суурилсан өвчлөлийн статистик мэдээлэл, халдварт бус өвчний эрсдлийн хяналт, хариуцлага, мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх** | Зонхилон тохиолдох хавдар болон халдварт бус өвчний тэргүүлэх өвчлөлийн мэдээлэл дээр суурилсан хяналтын тогтолцоог бий болгоно. | Хяналтын тогтолцоо бий болгосон байдлаар | - | - | Хяналтын тогтолцоо бий болсон байна. | **ЭМГ, АНЭ, сум, өрхийн ЭМТ** | Аймаг, сумын ЗДТГ |
| | | Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн бүртгэлийн маягтыг цахимжуулж мэдээний сан үүсгэнэ. | Үүсгэсэн цахим мэдээллийн сангаар | - | - | Мэдээний цахим сан үүссэн байна. | ЭМГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт4. ХБӨ-өөс урьдчилан сэргийлэх, хянахад үндэсний болон орон нутгийн байгууллагын чадамж, манлайлал, засаглал болон нийгмийн бусад салбар, олон улсын байгууллагын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах** | | | | | | | | |
| 4.1 | **ХБӨ-өөс сэргийлэх, хянах үйл ажиллагааны зохицуулалт, ажлын уялдааг сайжруулах** | **Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, ЭЗН-н хөгжлийн бодлогын чиглэл, төлөвлөгөөнд ХБӨ-с сэргийлэх, хянах асуудлыг тусгаж, үр дүнг тооцно.** | **Хэрэгжилтийн хувийн өсөлт, үр дүнгээр** | 75% | 77% | 78% | **ЭМГ, АНЭ, сум, өрхийн ЭМТ** | Аймаг, сумын ЗДТГ, төрийн болон ТББ |
| | | Халдварт бус өвчний чиглэлээр ажиллаж байгаа эмч мэргэжилтнүүдийн хангалтыг сайжруулах, мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг тогтмолжуулна. | Чадавхжсан эмч, мэргэжилтнүүдийн хувиар | 80% | 83% | 85% | ЭМГ, АНЭ | сум, өрхийн ЭМТ |
| | | Хорт хавдар болон архины хортой хэрэглээ, түүнээс үүдэлтэй сөрөг үр дагаврыг бууруулахаар ажиллаж байгаа төрийн бус байгууллагын санал, санаачлагыг дэмжнэ. | Дэмжлэг үзүүлсэн ТББ-ын тоогоор | 1 | 2 | 2 | ЭМГ, Аймаг, сумын ЗДТГ | АНЭ, сум, өрхийн ЭМТ |
| | | Өсвөр үе, залуучуудын дунд сэтгэцийн болон донтох өвчин, ялангуяа хар тамхи, мансууруулах бодис, архинаас хамааралтай болохоос сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг мэргэжлийн байгууллага, холбогдох төрийн болон ТББ-тай хамтран ажиллана. | **Хамтран ажилласан ТББ, сургалт, сурталчилгаанд хамрагдсан хүний тоогоор** | 500 | 500 | 500 | ЭМГ, АНЭ | АНЭ, сум, өрхийн ЭМТ, Аймаг, сумын ЗДТГ, ТББ |

Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөө, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

| | Шалгуур үзүүлэлт | Эх үүсвэр | Суурь үзүүлэлт /2018 он/ | Хүрэх үзүүлэлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 2019 он | 2021 он |
| **Үр дүнгийн шалгуур үзүүлэлт:** | | | | | |
| **Халдварт бус өвчний эрт илрүүлэлт, өвчлөлийн үзүүлэлт** | | | | | |
| 1. | Умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан хүн ам, хувиар (30-60 нас) | Төв аймгийн эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 он | 53.84 | 56.8 | 57.8 |
| 2. | Хөхний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан хүн ам, бодит тоо(30-60 нас) | Төв аймгийн эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 он | 18578 | 19507 | 20436 |
| 3. | Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан хүн ам, хувиар (40-65 нас) | Төв аймгийн эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 он | 11.70 | 30.0 | 70.0 |
| 4. | Элэгний хорт хавдар эрт үе шатандаа оношлогдсон хувь (I,II үеийн эзлэх хувь) | Төв аймгийн эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 он | 34.88 | 35.0 | 35.8 |
| 5. | Умайн хүзүүний хорт хавдар эрт үе шатандаа оношлогдсон хувь (I үеийн эзлэх хувь) | Төв аймгийн эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 он | 14.28 | 42.5 | 62.5 |
| 6. | Цусны даралт ихсэх өвчинг эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан хүн ам, хувиар (40-64 нас) | Төв аймгийн эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 он | 67.29 | 72.3 | 77.3 |
| 7. | Чихрийн шижинг эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан хүн ам, хувиар (40-64 нас) | Төв аймгийн эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 он | 65.63 | 70.6 | 75.6 |
| **Хөтөлбөрийн үр нөлөөний шалгуур үзүүлэлт:** | | | | | |
| 1. | Хорт хавдраас шалтгаалсан нас баралт (10 000 хүн амд) | Төв аймгийн эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 он | 12.71 | 12.0 | 10.5 |
| 2. | Зүрх судасны тогтолцооны шалтгаант нас баралт (10000 хүн амд) | Төв аймгийн эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 он | 21.14 | 20.8 | 20.4 |
| 3. | Бөөрний сувганцрын үрэвсэлт өвчний улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгч, хувиар | Төв аймгийн эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 он | 10.50 | 10.5 | 10.0 |

---oOo---